


Санхүүгийн салбарын тойм

Санхүүгийн салбарын нийт актив 2014 оны эцсийн байдлаар 23.5 их наяд төгрөгт хүрээд байна. Үүний 96%-ийг банкны салбар дангаар бүрдүүлж буй юм.

Өөрөөр хэлбэл бизнесийн орчин, улмаар эдийн засгийн нөхцөл байдал банкны салбараас хараат хэвээр байна. Энэхүү ганц тулгуурт санхүүгийн

тогтолцоо нь бизнес эрхлэгчид болон иргэд зээл, хөрөнгө оруулалтын хэрэгцээгээ хангах боломжит сонголтыг бууруулж байна. Санхүүгийн салбарт банкны зээлээс бусад эх үүсвэрээр санхүүжилт олж авах нөхцөлийг бий болгох хэрэгцээ өндөр байна.

Санхүүгийн салбарын бүтэц, мэргэжлийн оролцогчдын тоо, нийт активын хэмжээ



Банкны салбарын тойм

Санхүүгийн салбарыг тодорхойлогч банкны салбарын нийт хөрөнгө 21 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь ДНБ-ий хэмжээнээс 4.5 дахин өндөр үзүүлэлт юм.


Олон улсын жишгээр хөгжингүй орнуудын банкны салбарын хөрөнгө ДНБ-ээсээ өндөр байдаг нь тухайн салбар харьцангуй сайн хөгжсөнийг илтгэдэг. Нөгөө талаар банкны салбар нь эдийн засгийн нөхцөл байдлын тусгал нь болдог.

Манай улсын эдийн засаг өндөр өсөлттэй байсан 2011-2013 онуудад банкны салбарын нийт хөрөнгийн өсөлт жилийн 30-75 хувь байв. Харин 2014 оноос эдийн засгийн өсөлт саарсантай холбоотой банкны салбарын өсөлт харьцангуй удааширч, энэ нь 2015 онд хадгалагдах хандлагатай байна.

Олон улсын байгууллагууд 2015 оны эдийн засгийн өсөлтийг 3-5 хувь байхаар таамаглаад буй бөгөөд 5 дугаар сард Оюутолгойн Далд уурхайг ажиллуулах гэрээнд талууд гарын үсэг зурснаар эдийн засагт тодорхой хэмжээний эерэг хүлээлтийг үүсгэж байна.

Мөнгө, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд

(1У'15, их наяд төгрөг)




БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – I улирал




Банкны салбарын актив, их наяд төгрөг




Салбарын нийт актив 2015 оны эхний улирлын байдлаар 21 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4% өссөн бол өмнөх улирлаас 8% буурчээ.

Банкны салбарын өсөлт 2014 оны эхний улирлаас эхлэн саарч, цаашид тогтворжих хандлагатай болоод байна. Энэ нь эдийн засгийн өсөлт удааширсан, Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн үр нөлөөний оргил үе шувтарсан, банкны хөрөнгийн үндсэн бүрдэл болох зээл олголт нэмэгдэхгүй байгаатай холбоотой.

Нийт зээл, их наяд төгрөг




Нийт активын бүтэц, 1У'15




Нийт зээл 12 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 8.6% өссөн бол өмнөх улирлаас 1.9% буураад байна. Эдийн засгийн өсөлт удааширч бизнесийн орчны идэвхжил буурсан, зээлийн эрсдэл даах чадвартай иргэд, бизнес эрхлэгчдийн эрэлт буурсан зэрэг нь үүнд нөлөөлж байна.

Ипотекийн хөнгөлөлттэй зээлийг 2013 оны 6 сараас эхлэн олгосон бөгөөд энэ оны эхний улирлын байдлаар нийт 49 мянган иргэнд 2,2 их наяд төгрөгийн зээл олгоод байна.

Ипотекийн зээл, их наяд төгрөг



Чанаргүй зээл, тэрбум төгрөг




Нийт зээлийн 3.9% нь чанаргүй зээл ангилалд багтаж байна. Зээлийн өсөлтийн хурд саарч байхад чанаргүй зээлийн эзлэх хувь өсч буй нь зээлийн чанар муудаж, цаашид банкны салбарын нийт хөрөнгийн чанар муудах эрсдэлтэй байгааг анхааруулж байна.

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – I улирал




Хадгаламж ба харилцах, их наяд төгрөг



Банкны салбарын үндсэн эх үүсвэр болох хадгаламж, харилцахын дүн 9.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1% өссөн бол өмнөх улирлаас 6% буурчээ.


Өмнөх улиралтай харьцуулахад хадгаламж 8 тэрбум төгрөгөөр буурч байхад зээл 230 орчим тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ нь эрэлт буурч байгааг харуулж байна.

Зээл ба хадгаламж, харилцахын харьцаа




Зээл ба хадгаламж, харилцахын харьцаа эхний улирлын байдлаар 126 хувь хүрээд байна. Банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ сайжирч байгаа ч зээл ба хадгаламж, харилцахын харьцаа 100 хувиас илүү гарч байгаа нь хөрвөх чадварын эрсдэл нэмэгдэх, банкууд эх үүсвэрийн дутагдалд орох эрсдэл байгааг сануулж байна.

Өөрийн хөрөнгө, их наяд төгрөг



Өөрийн хөрөнгө эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27 хувь, өмнөх улирлаас 2 хувь нэмэгджээ. Өөрийн хөрөнгийн хэмжээ тогтмол өсөх хандлагатай байгаа нь сайн үзүүлэлт юм. Түүнчлэн Монголбанкнаас арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэх шийдвэр гаргаад байна. Энэ нь банкны системийн эрсдэл даах чадварыг сайжруулах эерэг нөлөөтэй.

Хүүний динамик, төгрөгийн



Хадгаламж, зээлийн хүүний зөрүү буюу зуучлалын зөрүү өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 нэгж хувиар, өмнөх улирлаас 1 нэгж хувиар буураад байна. Энэ нь арилжааны банкуудын өрсөлдөөн ширүүсч, үйл ажиллагааны зардал буурч буйтай холбоотой байж болно.

Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд, улирлын өсөлт, хувь

	2013				2014				2015
	I	II	III	IV	I	II	III	IV	I
Активын өсөлт	10.8%	20.0%	13.9%	14.8%	-0.8%	3.4%	-2.2%	7.9%	-8.0%
Зээлийн өсөлт	5.7%	16.6%	18.1%	3.1%	5.9%	8.9%	2.6%	-0.9%	-1.9%
Ипотекийн зээлийн өсөлт	6.9%	14.2%	56.1%	20.3%	13.1%	11.2%	7.3%	8.6%	6.0%
Чанаргүй зээлийн хувь	4.2%	3.7%	5.3%	2.5%	2.6%	2.7%	2.8%	3.1%	3.9%
Харилцахын өсөлт	-7.6%	22.3%	8.4%	-3.0%	-10.8%	8.1%	7.0%	7.5%	-22.3%
Хадгаламжийн өсөлт	-0.7%	3.3%	5.6%	20.0%	12.5%	-0.8%	-2.3%	5.9%	-0.1%
Өөрийн хөрөнгийн өсөлт	4.1%	11.1%	6.2%	9.3%	41.7%	6.5%	5.4%	10.9%	2.1%

Банкны салбарын онцлох үйл явдлууд

- 01.15** Монголбанк *бодлогын хүүг* 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн, *13 хувь болгох* шийдвэр гаргалаа.
- УИХ “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай тогтоол”-ийг баталлаа. Энэхүү тогтоолд 2015 оны эхний хагас жилд багтаан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийн зээлээс Монголбанкны тэнцэлд үлдэх хэсгийг Засгийн газарт шилжүүлэх, Төрийн банк олон улсын зах зээлд 300 сая ам.долларын бонд гаргах зорилт тусгагдаад байна.
- 02.18** *Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг шилжүүлэх* ажлын хүрээнд холбогдох талууд уулзан хөтөлбөрүүдэд эцсийн байдлаар үнэлгээ хийсэн бөгөөд цаашид зах зээлийн зарчимд нийцсэн тогтвортой тогтолцоог Засгийн газар бүрдүүлэх, нийлүүлэлтийн гаралтай инфляци өсөх эрсдлийг бага байлгаж ажиллах нь зүйтэй гэж үзжээ.
- 04.01** Монголбанк *арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг* байхаар шинэчлэн тогтоолоо. Энэ шаардлагыг биелүүлэх хугацааг банкны төлбөрийн чадвар, үйл ажиллагааны онцлогоос хамааран харилцан адилгүй тогтоож, 2017 оны 12 сарын 31-ний өдрийг эцсийн хугацаа байхаар шийдвэрлэжээ.
- 04.10** Монголбанк *бодлогын хүүг хэвээр хадгалах* шийдвэр гаргалаа.
- ХХБ* Засгийн газрын баталгаатай, дунд хугацаат (5 жил), *500 сая ам.долларын бонд* гарган дэлхийн зах зээлд арилжааллаа.
- 05.19** Арилжаалагдсан бондын 90%-ийг дэлхийн нэр хүндтэй хөрөнгийн удирдлагын компаниуд, 5%-ийг банкууд, 5%-ийг санхүүгийн байгууллагууд худалдан авч хөрөнгө оруулалт хийжээ. ХХБ өмнө нь мөн амжилттай бонд гаргаж (2007, 2010, 2012, 2014 онуудад) байсан туршлагатай юм.

Банкуудын өрсөлдөөний тойм

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2015 оны эхний улирлын байдлаар банкны салбарт нийт 14¹ арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно.

Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Өөрийн хөрөнгө
- Ашиг

Түүнчлэн банкны үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэгч зарим нэг харьцаа, үзүүлэлтүүдийг тооцлоо.

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан.



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк
Улаанбаатар хотын банк

БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг


Капитал банк
Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Кредит банк
Тээвэр хөгжлийн банк

¹ Хадгаламж банк 2013 оны 7 сард Төрийн банктай нэгдсэн. Богд банк шинээр (2014 оны сүүлээр тусгай зөвшөөрлөө авсан) байгуулагдсан.

АКТИВ

Арилжааны банкуудын нийт активын 67 хувь нь Том-3 банкинд төвлөрч байна. Үүнээс зах зээлд эзлэх байр сууриар ХХБ хамгийн их буюу зах зээлийн 25 хувийг эзэлж байна. Түүний дараа Хаан банк 24% хувийг буюу ойролцоо хувь эзэлж буй юм.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 1У'15



Банкуудын нийт актив² эхний улирлын байдлаар 20 их наяд төгрөгт хүрэв.

Том-3 банкны нийт актив өнгөрсөн жилээс 236 тэрбум төгрөгөөр буюу 1.8 хувь өссөн байна.


Дунд-3 банкны хувьд Хасбанк 183 тэрбум төгрөгөөр буюу 10 хувиар активаа өсгөж чаджээ.

Харин бусад ангилалд багтсан 8 банкны нийт актив 269 тэрбум төгрөгөөр буюу 20.5 хувь өсчээ.


Том, дунд банкуудтай харьцуулахад бусад ангилалд багтсан банкуудын активын өсөлт илүү хурдтай байна. Энэ нь эдгээр банкуудын зээл олголт илүү хурдтай нэмэгдэж буйтай холбоотой.

Тайлант хугацаанд активын хамгийн өндөр өсөлтийг Ариг банк үзүүлсэн бөгөөд хөрөнгөө 60 орчим хувиар өсгөж чаджээ.


Том-3 банк



Дунд-3 банк



Бусад банкууд



² Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцсон.

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ


2015 он – I улирал

ЗЭЭЛ

Банкуудын нийт зээлийн 67 хувийг Том-3 банк, 25 хувийг Дунд-3 банк, 8 хувийг бусад банкууд хянаж байна. Активын хэмжээгээр ХХБ тэргүүлж байсан бол зээлийн дүнгээр Хаан банк зах зээлийн 25 хувийг эзэлж буйгаараа тэргүүлсэн байна.

Богд банк одоогоор зээл гаргаагүй байна.

Зах зээлд эзлэх хувь, зээлээр, 1У'15





Зээлийн өсөлтийн хурдаар Бусад ангилалд багтсан банкууд буюу Ариг, ҮХОБ, Капитал, Кредит, Чингис хаан банкууд хамгийн өндөр өсөлт (дунджаар 40%) үзүүлжээ. Дунд-3 банкуудаас Хасбанк 17 хувийн өсөлт гаргажээ.

Том-3 банкны хувьд Хаан банк зээлээ 11 хувь нэмэгдүүлсэн амжилттай байгаа бол Голомт банк зээлийн өсөлт үзүүлж чадсангүй. ХХБ активын дүнгээр зах зээлд тэргүүлж байгаа бол зээлийн дүнгээр Хаан банк тэргүүлэх байр суурьтай байгаа юм.


Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх олгохоор байгаа боловч зах зээлийн нөхцөл байдал, иргэдийн зээл авах чадвар зэргээс шалтгаалан өсөлтийн хурд нь саараад буй юм. Системийн нийт зээлийн өсөлтийн хурд удааширнаас банкуудын зээл мөнгөн дүнгээрээ төдийлөн их хэмжээгээр нэмэгдээгүй байна.

Том-3 банк

Дунд-3 банк




Бусад банкууд



ХАРИЛЦАХ БА ХАДГАЛАМЖ

Нийт харилцах ба хадгаламжийн 67 хувийг Том-3 банк, 27 хувийг Дунд-3 банк, үлдсэн 6 хувийг бусад банкууд бүрдүүлж байна.

Эх үүсвэрийн хэмжээгээр Хаан банк тэргүүлж, ХХБ, Голомт банкууд удаалсан байна. Богд банк одоогоор харилцах ба хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.



Эх үүсвэр бүрдүүлэлтийн хувьд мөн Бусад ангилалд багтсан банкууд илүү хурдтай өсөлтийг үзүүлжээ. Тухайлбал Ариг банк татан төвлөрүүлсэн хөрөнгөө 2.5 дахин нэмэгдүүлж чадсан байна.



Том-3 банкны хувьд эх үүсвэр 148 тэрбум төгрөг буюу 2 хувь буурчээ. Голомт банк харилцах ба хадгаламжаа 14 хувь нэмэгдүүлсэн боловч Хаан, ХХБ-ны хувьд энэ үзүүлэлт тус тус 5%, 12% буурсан байна.

Дунд-3 банкны тэргүүлэгч Төрийн банкны эх үүсвэр мөн буурсан бол Хасбанк эх үүсвэрээ 16% нэмэгдүүлсэн амжилттай байна.


Бусад ангиллын банкуудаас Капитрон, Кредит, ТХБ-ны татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт нь хасах утгатай гарчээ.

Том-3 банк

Дунд-3 банк



Бусад банкууд



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Банкуудын нийт өөрийн хөрөнгийн 72 хувь нь Том-3 банкинд, 21 хувь нь Дунд-3 банкинд, 7 хувь нь бусад банкуудад байршиж байна.

Өөрийн хөрөнгийн дүнгээр Хаан банк тэргүүлсэн байна.

Өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдаар Капитал банк тэргүүлж, ХХБ, Хасбанк удаалав.


Том-3 банк өөрийн хөрөнгийн хувьд өндөр өсөлт үзүүлж нийт дүнгээрээ 370 тэрбум төгрөг буюу 29 хувиар нэмэгдүүлсэн байна.

Бусад ангиллын банкууд өөрийн хөрөнгөө 45 тэрбум төгрөгөөр буюу 35 хувиар өсгөжээ.


Дунд-3 банкууд мөн өөрийн хөрөнгийн хувьд өсөлттэй байна. Хасбанк 26 хувийн өсөлт, Төрийн банк 11 хувийн өсөлт тус тус үзүүлжээ.

Харин Ариг банк, Кредит банкны хувьд өөрийн хөрөнгийн өсөлт хасах утгатай байна.


Зах зээлд эзлэх хувь, өөрийн хөрөнгөөр, 1У'15




Том-3 банк



Дунд-3 банк



Бусад банкууд



ХАРЬЦАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД


[Зээл/Харилцах ба хадгаламж] харьцаа

Энэ харьцаа нь банкууд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө хэдэн хувийг зээл болгон гаргаж буйг харуулна.

Хэт өндөр байвал эх үүсвэрийн дутагдалтай буюу дотоодын зах зээлээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн дутагдалтай байх, зээлийн эрсдэл үүсэх, банкууд гадаад эх үүсвэрийг ихээхэн ашиглаж байгааг илтгэнэ. Бага байвал эх үүсвэрийн илүүдэл үүсэх, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Банкуудын дундажаар энэ харьцаа 115 хувь байна. Өөрөөр хэлбэл банкууд харилцах ба хадгаламж хэлбэрээр бүрдүүлсэн эх үүсвэрээс илүү их хэмжээгээр зээл олгоод байна.


Эхний улирлын байдлаар Төрийн банк, УБХБ, Ариг банкууд эх үүсвэрийн илүүдэлтэй байна. Эдгээр банкууд цаашид зээлээ өсгөх бодлого хэрэгжүүлэх болов уу. Харин бусад банкуудын хувьд энэ үзүүлэлт 100-аас өндөр байгаа нь гаднаас төслийн болон бусад эх үүсвэрүүд орж ирж буйтай холбоотой хэмээн таамаглаж байна.



[Хүүний зардал/Хүүний орлого] харьцаа

Банкуудын үр ашигтай үйл ажиллагааг хэмжих энэхүү үзүүлэлт нь хүүний орлогын хэдэн хувь нь зардал болон гарч буйг харуулна. Бага байвал үйл ажиллагааны зардал бага, ашиг өндөр байна гэж ойлгож болно.

Системийн нийт дүнгээр энэ үзүүлэлт 62 хувь байна. Хамгийн хямд эх үүсвэртэй банкууд нь ТХБ, Кредит банкууд байна. Тайлант хугацаанд Капитрон банк зардлаа хамгийн их хувиар бууруулж чаджээ.



БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – I улирал

АШИГТ АЖИЛЛАГАА


Арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд энэ оны эхний улиралд нийт 78 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх) ажиллажээ.

Нийт өөрийн хөрөнгө 2.3 их наяд төгрөгт харьцуулбал өөрийн хөрөнгийн 100 төгрөг тутамд 3.4 төгрөгийн ашигтай ажилласан байна.


Эхний улирлын байдлаар Хаан банк хамгийн өндөр ашигтай ажилласан байна. Түүний араас ХХБ, Голомт банкууд удаалж явна. Харин Тээвэр хөгжлийн банк, Капитрон, Ариг банкууд алдагдалтай байв.

Ашгийн хэмжээгээ нэг жилийн дотор хамгийн өндөр өсгөсөн банк Хаан банк байсан бөгөөд улирлын ашгаа 55 хувь нэмэгдүүлж чаджээ.

Том-3 банк



Дунд-3 банк



Бусад банкууд



Эх үүсвэр:

Санхүүгийн болон Банкны салбарын тойм хэсэгт Монголбанк (2013 оны 4 дүгээр улирлаас хойш татан буугдсан банкуудын дүнг хассан статистикийг ашиглав), Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны мэдээллийг ашиглав. Банкуудын өрсөлдөөний тойм хэсэгт арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайланг ашиглав.

Товчилсон нэрс:

1Y'15 2015 оны 1 дүгээр улирал
ББСБ Банк бус санхүүгийн байгууллага
ДНБ Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОСИСТТБ Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр
УБХБ Улаанбаатар хотын банк
ҮХОБ Үндэсний хөрөнгө оруулалтын банк
ҮЦЗЗ Үнэт цаасны зах зээл
ХЗХ Хадгаламж, зээлийн хоршоо
ХХБ Худалдаа хөгжлийн банк